

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРААС
2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024.10.04

Нэг. Салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр:

1.1. Хүрээлэн буй орчин, Хог хаягдлын менежментийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх:

Сүхбаатар аймгийн Байгаль орчин аялал жуулчлалы газар, Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ хамтран Тулгар төрийн 2233, Их монгол улсын 818, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсаны 113, ардын хувьсгалын 103 жилийн ой, аймаг байгуулагдсаны 82 жилийн ойн баяр наадмаар ил задгай хог хаягдлаас урьдчилан сэргийлэх, хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг суулгах замаар хог хаягдал, дахивар бүтээгдэхүүн худалдан авч холивол хог ангилбал баялаг гэдгийг наадамчин олонд харуулж хог хаягдал, дахивар хог худалдан авах цэг үүсгэж хуванцар сав, нэг удаагийн аяга, бусад хогийг үнэлж урамшуулалт худалдан авалт хийж хоггүй цэвэрхэн наадлаа.

Баяр наадмын өдрүүдэд зохион байгуулсан арга хэмжээнд нийт 1000 гаруй хогны уутыг тарааж нийт 520 гаруй удаагийн худалдан авалт хийж гүйцэтгэн 1.110.000 /нөат 10% 111.000 суутгаж/ 999.000 төгрөгийг зарцуулж ажилласан байна. Хогны уут гар ариутгагч, бээлий, сальфетка зардалд -189.500, Аннос сурталчилгаа нөлөөллийн ажилд 360.500 төгрөгийг тус тус зарцуулж ажилласан байна.

Хандлагаа өөрчлөө- Цэвэрхэн наадацгаая уриа бүхий аннос хэвлэлийг худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд байршуулсан.

Арга хэмжээний үеэр ирсэн дахивар хогийг ширхэглэн тоолж бусад хогийг уутаар үнэлэн худалдан авалт хийсэн. Мөн хүн бүрт нэг удаагийн бээлий, нойтон сальфетка өгч гарыг арчуулан санитал гар ариутгагч гелээр гарыг ариутгасан.

Энгийн болон дахивар хог худалдан авах цэгийг үүсгэж, ангилан ялгах 2 ш хогийн савыг хийж байршуулсан.

Урамшуулалт худалдан авалтанд хамрагдаж, хог тушаасан хүн бүрт тооцоог нь бэлнээр өгч гарын үсэг зуруулж ажилласан.

Ирсэн хогийг ангилан ялгаж дахивар болон бусад хогоор нь ангилан ялгах нөлөөллийн ажил.

Баяр наадмын өдрүүдэд ниит 2 машинд дахивар болон бусад гэсэн 2 төрлөөр хогийг ангилан хийж 2 машины тэвш дахивар хог 2 машин бусад хог нийт 4 машин хогийг төвлөрүүлж хогийн нэгдсэн цэг болон дахивар хадгалах агуулах руу буулгасан байна.



2. Хог хаягдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэхь заалтыг үндэслэн орон нутагт үйл ажилллагаа явуулж байгаа аюултай хог хаягдал үүсгэгч

Шатахуун үгээх станцуудыг аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгэн Y-001976, Y-001979, дугаар олголт хийлээ.

3. Хог ургамал цэвэрлэгээ, Баруун урт суманд Хоггүй маргаашыг хамтдаа бүтээе уриан дор бүх нийтийн цэвэрлэгээг байгууллагын эзэмшлийн талбайд зохион байгуулж хийж гүйцэтгэлээ.

4. Хог хаягдлын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах хүсэлтэй иргэдэд орчны бохирдлыг бууруулах, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах мэдлэг чадварыг олгож, орон нутгийн хог хаягдлын менежментийн сайн туршлагыг хуваалцах улмаар улсын хэмжээнд хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлын менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой, 2024 оны 09 сарын 23-28 өдрүүдэд Европын холбооны санхүүжилттай Каритас чех републик олон улсын байгууллагаас Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах төсөл сумын хог хаягдлын менежментийн сайн туршлага судлах хөтөлбөрт хамрагдаж ажиллаа.



5. Аймгийн Агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийг боловсруулж АЗДТГ-хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэст ИТХ- хуралд оруулж батлуулахаар хүргүүлсэн.

7. Гарын авлага -1 , шторк -2 , постер – 11 бэлтгэж байгууллагын пэйж хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар олон нийтэд хүргэсэн байна.

1.2. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх:



Хил орчмын аялал жуулчлалыг гадаадын жуулчдад сурталчлах үүднээс аймгийн Засаг даргын 2024 оны А/202 дугаар захирамж гарч 2,250,0 мянган төгрөгөөр Монгол, Хятад хэл дээр аяллын маршрут, хөтөлбөр бүхий товхимолыг 500 ширхэгийг хэвлүүлсэн. Товхимолыг Мөнхийн үсэг ХХК-иар хэвлүүлсэн.

Ингэснээр аялал жуулчлалын компани болон жуулчид аялалын талаар нэгдсэн мэдээллийг авах боломжтой болсон.



Монгол улс Сүхбаатар аймаг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн удирдлагуудын уулзалт болсон

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошууны Засаг даргын орлогч Шюй Инжянь тэргүүтэй зочид төлөөлөгчид Сүхбаатар аймагт албан айлчлал хийж,

аймгийн удирдлагуудтай уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтаар хоёр талын боомтыг хөгжүүлэх болон авто зам, төмөр замын бүтээн байгуулалт БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошуу болон Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум хооронд Олон улсын ах дүү хот байгуулах Эрдэнэцагаан суманд өвсний гэрээгээр баригдсан зочид буудлын барилгыг хүлээлгэж өгөх гарц боломж Хил орчмын хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамтарч ажиллах

□Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, хил орчмын аялал жуулчлалын маршрутыг өргөтгөх, Сүхбаатар аймаг ирэх жилүүдэд аялал жуулчлалын салбарын бодлогод онцгойлон анхаарах зэрэг тодорхой сэдвүүдийн хүрээнд харилцан санал солилцож, цаашид хамтран ажиллах боломжийн талаар хэлэлцлээ.

Ганга нуурын шувуу ажиглах нуувч хийлээ.



Аймгийн Засаг даргын 2024 оны А/347 дугаар захирамжаар шувуу ажиглах нуувч хийх захирамж гарсан. Захирамжийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Дарьганга сумын иргэн Б.Отгонбаяртай Дарьганга сумын Ганга нууранд шувуу ажиглах нуувчыг хийж гүйцэтгэх 3.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Гэрээний дагуу шувуу

ажиглах нуувчыг хийж дууссан. Шувуу ажиглах нуувчтай болсноор Ганга нууранд

шувуу судлаач, шувууны гэрэл зурагчдыг татах, тусгай сонирхлын аяллыг хөгжүүлэх алхам бүрдэж байна.



Дэлхийн аялал жуулчлалыг өдрийг тохиолдуулан мэргэжил сурталчилах арга хэмжээг зохион байгууллаа.

Дэлхийн 158 улс орныг эгнээндээ нэгтгэсэн НҮБ-ын дэлхийн Аялал жуулчлалын байгууллагаас жил бүрийн есдүгээр сарын 27-ны өдрийг “Дэлхийн аялал жуулчлалын өдөр”

болгон тодорхой уриан дор тэмдэглэн өнгөрүүлдэг. ДАЖБ-ын гишүүн 154 орон 1980 оноос, харин Монгол Улс 1990 онд ДАЖБ-ын гишүүн болж, 2007 оноос хойш жил бүр тэмдэглэж байна. 2024 онд Дэлхийн аялал жуулчлалын өдрийг Аялал жуулчлал ба энхтайван эв нэгдэл уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байна. Уг өдрийг тохиолдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Баруун-Урт сумын засаг даргын тамгын газар хамтран Баруун-Урт сумын ЕБ 3-р сургуулийн 9, 10, 11 дүгээр ангийн нийт 427 сурагчдад аялал жуулчлалын салбарын ач холбогдол, аялал жуулчлалын мэргэжлийн онцлог, давуу тал болон аймаг орон нутгийн аялал жуулчлал, түүх соёлын дурсгалыг хэрхэн хамгаалах, түүний ач холбогдолын талаар мэдээлэл өгч ажиллаа. Хичээлийн явцад хичээлд идэвхтэй оролцсон сурагчдад англи хэл дээр хэвлүүлсэн Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын газрын зургийг гардуулж өгсөн. Хичээл заах орчин нөхцлийг бүрдүүлж өгсөн ЕБ 3-р сургуулийн Газарзүйн багш Т.Жавзандулам багшдаа гүн талархал илэрхийлье.

Зочид буудлын аттестатчилал зохион байгууллаа:

Аймгийн Засаг даргын 2024 оны А/203 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудлуудад аттестатчилал зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар Г.Сугараа, гишүүдээр Э.Сансартайван, Ц.Өлзийжаргал, Т.Амарбат, М.Дамба, П.Ариунболд, П.Болортунгалаг нар ажиллаа. Ажлын хэсэг Баруун-Урт сумын Наадаан ресорт, Дарьганга зочид буудалд шалгалтыг эхлүүлээд байна. Шалгалтын явцад буудлууд зочдын аюулгүй байдлыг хангах үүднээс эмч, эмнэлгийн байгууллагатай гэрээ хийх, зочны тээш хадгалах үйлчилгээ, яаралтай түргэн тусламж, шаардлагатай утасны жагсаалт, өрөө бүрт бүү саад бол тэмдэг тэмдэглэгээ, нийтийн өлгүүр, халдваргүйжүүлэлт, ариутгалжуулалт, шавьжгүйтэл хийлгэх, ундны усны шинжилгээ хийлгэх, гэрээт харуул хамгаалалттай байх,

температур хэмжигч байрлуулах зэрэг зөрчил гарч байна. Цаашид аймгийн төвийн бүх зочид буудлуудад шалгалт хийгдэнэ.

1.3. Ойжуулалт, ногоон байгууламж, гамшгийн чиглэлээр:

Бүх нийтээр мод тарих өдрийг угтан тус байгууллага Усалья, Арчилъя, Хамгаалья уриа дор 5сарын- 8ны өдөр “Тарьц суулгац -2024” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 6-н аж ахуй нэгж байгууллага, 1иргэн оролцож 14 нэр төрлийн 60.000 гаруй мянган тарьц суулгацаар оролцож 40000 гаруй мянган мод худалдаалагдсан дүнтэй байна. Цаашид сумууд болон аймгийн төвийн иргэн ААНБ-д дээрх мод үржүүлгийн газруудаас хавар, намрын нөхөн тарилтын модны нөөцөө бүрдүүлэх бүрэн боломжтой. Одоогийн байдлаар 100000 гаран мянган модны нөөцийг мод үржүүлгийн 12 ААНБ, иргэд бүрдүүлээд байна.

Мөн хүнсний ногоон үрсэлгээгээр 2 иргэн оролцож иргэдийн худалдан авалт сайн байлаа. Мод суулгацын үнийн хувьд 3000-55000 төгрөгийн хооронд худалдаалагдсан. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд 2021-2030 он хүртэл 10сая мод тарьж ургуулах үүрэг хүлээсэн. 2022-2023 онд аймгийн хэмжээнд 7 төрлийн 414570 ш мод таригдсан. 2024 онд аймгийн хэмжээнд 160000 мянган мод тарихаар зорилт тавин ажиллаж байна.

Монгол улсын ерөнхийлөгчийн 58-р зарлиг, Ойн тухай хуульд зааснаар Монгол улсын иргэн бүр 5ш мод , аж ахуй нэгж байгууллага хүний тоогоор 10ш мод тарих үүрэгтэй.

Хаврын мод тарилтын ажлын явц :

№	Сумын нэр	Умарсан		Төрийн байгууллага, ААН		Бяг, хороонд шинээр байгуулсан				Таригдсан мод		Нийт модны тоо	Мод тарьсан нэг арга тоо	Мод тарьсан нэг арга тоо	Мод тарьсан нэг арга тоо	Нийт зарцуулсан зардлын тооцоо
		Хавардээ тарьсан модны тоо	Мод тарьсан арганы тоо	Орчин тойрон болон бичиг цэвэрлэг, гэд	Нэрэмжит ой тогтолд байгуулсан үржмэл модны тоо	Тарьсан модны тоо	Шинээр байгуулсан бичиг цэвэрлэгийн нүр	Тогттой гэмээр м2	Тарьсан модны тоо	Зурагжуулалтын модны м2	Байгуулсан модны м2					
1	Асгат	78	8	1500	1	946						8	1932	153	4	3200000
2	Баруун-үрл	2000	100			10818	1	1	230			13048	1164			5364.090.000
3	Баяндэлгэр	600	200		4	2000						2600	450			4.12.100.000
4	Дарьганга	450	45	24000	1.5	900						25350	150			5.105.775.000
5	Менхсэлэн	1975	265	500								2475	795			45.250.000
6	Наран	58	11	265								323	181			1.776.500
7	Онгон	96	11	390								486	80			3.16.000.000
8	Уулбаан	108	10	400	2	680	1	1.5	650			1838	260			6.22.000.000
9	Халзан	800	120	60								860	186			8.5.160.000
10	Сүрбэлтэр	2000	400	8000	1.5	200	1	1.5	205			10405	800			6.70.172.000
11	Түвшинтэс	400	30	1050								1450	162			5.4.253.000
12	Түвшинтэс			19060								19060	34			1.80.000.000
13	Эрдэнэцагаан	1600	480	1980								3580	960			12.12.000.000
14	Нийт	10165	1680	57205	10	14944	3	4	1085			83407	5355			111.401.856.500

Нийт 4 төрлийн / улиас, бургас, агч, гацуур / 37390 ширхэг мод тариад байна. Үүнээс Дарьганга суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 24000 мянган мод нь татмын ойжуулалтаар таригдсан. Цаашид ААНБ, Айл өрх, Уул уурхайн ХХК-уудыг идэвхжүүлэх шаардлагатай байна.

Бүх нийтээр мод тарих аяны хүрээнд БОАЖГ-ын хамт олон ЕБ-ын 3-р сургуулийн 86 ангийн эко клубийн сурагчидтай хамтран Боловсрол төглийн хашаанд шинээр 83 мод тарьж усалгааг арчилгаа хийж ажиллаж байна. Мөн өөрийн байгууллагын бичил цэцэрлэгт хүрээлэнд 12 мод нөхөн тарилтаар тарьж усалж цэвэрлэгээ хийж ажиллаа. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд БОАЖГ-ын төвийн ажилчид тус бүрд монос 3ширхэг үхрийн нүд 2ширхгийг, Мөн сурагчдын зөвлөл санаачлаг гарган аян зохион байгуулж Баруун урт суманд мод тарих ажил эхлүүлж дэмжиж 90ширхэг монос, үхрийн нүд зэрэг модыг хандивласан.

Мөн Баруун-урт сумын нийтийн эзэмшлийн талбайд ургаж байгаа улиас модонд залуужуулах, хэлбэршүүлэх ажлыг 4-н Аж ахуй нэгж байгууллагын 16 ажилтан 3500 модонд тайралт таналт хийж ажиллаа





Гамшгаас хамгаалах хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд Ой хээрийн түймэр гарах эрсдэл бүхий Дарьганга, Эрдэнэцагаан, Асгат, Мөнххаан, Сүхбаатар, 5-н суманд түймэр унтраагч багаж 2 ширхэг буюу нийт 10ш үлээгч аппарат хүлээлгэн өгсөн. Мөн дээрхи сумын хөдөөгийн малчин өрх 3214 –д ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх меесеж мэдээг Юнител ХХК. Ус цаг уур орчны шинжилгээний газартай хамтран хүргэж байна. Мөн Ой хээрийн түймрээс урьдчилан зорилгоор Түмэнбарбарис ахмадын нөхөрлөлтэй нэг сая төгрөгийн гэрээ байгуулж нөлөөллийн ажлыг мөнххаан түмэнцогт сумын иргэдэд хийхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна. Мөн аймгийн Засаг даргын захирамж гарган ажиллсан



1.4. Биологийн төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр.



Дэлхий дахинд “Олон улсын Биологийн олон янз байдлын өдөр”-ийг тэмдэглэж байна. энэ жилийн хувьд “Хамтдаа төлөвлөж хамтдаа хэрэгжүүлье” уриан дор тэмдэглэж байгаа бөгөөд Сүхбаатар аймгийн БОАЖГ, ИТХ-аас тус өдрийн тохиолдуулан “ХАЙРЛАЯ ХАМГААЛЪЯ ХАМТАРЪЯ” ток шоу амжилттай зохион байгуулж нийт 5 сумын 8 эко кулбийн төлөөлөл болон

ЕБС -ын 500 орчим сурагчдад Хялганат хээрийн чимэг Цагаан зээрийн талаар мэдээллийг хүргэн ажилласнаас гадна Цагаан зээрийг хайрлан хамгаалахад дуу хоолойгоо хүргэлээ.Сүхбаатар аймгийн хэмжээнд нүүрлэж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж сүүлийн жилүүдэд цагаан зээрийн тоо толгой эрс цөөрч байна. Иймд хүүхэд багачуудад цагаан зээрийн ач холбогдол, үнэ цэнийг ойлгуулах, тэдний оролцоог хангах зорилгоор байгаль орчны мэргэжлийн байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачдын төлөөлөл, малчин, сэтгүүлч, эко клубийн сурагчийн төлөөллийг урьж Цагаан зээрийг хайрлан хамгаалахад тулгарч буй асуудлын талаар өөр өөрсдийн байр суурийг илэрхийлж мэдээллийг аль болох олон талаас нь хүргэхийг зорьсон. Мөн арга хэмжээний үеэр “Цагаан зээрийн холбоос нутаг, гинжин хэлхээ” -ний чиглэлээр маш сонирхолтой танин мэдэхүйн тоглоомыг судлаач М.Ууганбаяр тоглуулж, Дарьгангын БЦГ-ын хамгаалалтын захиргаа

”Байгаль орчны нүүдэлчин хайрцаг” сургалт судалгааны хөтөлбөр,хэрэглэгдэхүүнийг танилцуулж байгаль хамгаалагч нарын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, материалуудаар үзэсгэлэн гаргасан нь сурагчдын олж авсан мэдээллийг улам их бататгалаа.

2023 онд “Янзаган хүрээг хайрлаарай” Зүүн бүсийн нэгдсэн чуулга уулзалтын үр дүнд оролцогч талууд “Тунхаг бичиг” гаргасан. Үүний хэрэгжилтийг хангах нэгэн ажил нь энэхүү арга хэмжээ байлаа.



ЕБС оролцсон.

Дээрх ажлыг амжилттай зохион байгуулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт биологийн олон янз байдлыг хамгаалах төсөл,Сүхбаатар аймгийн БШУГазар,ЕБС-ийн Здугаар сургууль, Нар тоссон мөрөөдөл ТББ болон холоос зорин ирж оролцсон Дарьгангын БЦГ-ын хамгаалалтын захиргаа, Мөнххаан, Сүхбаатар,Түмэнцогт сумын

1.5. Усны нөөцийн ашиглалт хамгаалалт:

Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх зорилгоор Мөнххаан сумын хэмжээнд ОНХС –15 сая төгрөгийн санхүүжилт гарган нийт 2 булаг “Хавцалын булаг, Гурван худгийн булаг зэрэг булгийг хашиж хамгаалсан. **Мөн Эрдэнэцагаан сум бавхайт булаг / ОНТ 5,0 сая / , Наран сум Өлзийт булгийг ОНТ –с 267 сая төгрөгөөр хашиж хамгаалах ажил хийгдэж байна.**




Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Баруун-Уртын голын онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд байрлах хог хаягдлыг цэвэрлэх, усны нөөцийг бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах гол зорилготойгоор Баруун-Урт сумын “Баруун-Уртын гол”-ын онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд байрлах төвлөрсөн бус хог хаягдлыг цэвэрлэх ажлын хүрээнд голын эргээс 2 км зайд байрлах малын сэг зэм, хуримтлагдсан хог хаягдалыг цэвэрлэж, ачиж тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт төвлөрүүллээ. Уг ажлыг гүйцэтгэхэд ковш-1, Хово-1, туслах ажилтан-5, ЗДТГазраас 1 албан хаагч нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй гарч 5 хоногийн турш ажиллаж голын дагуу урт 12 км, өргөн 2 км радиус нутаг дэвсгэр буюу 11 нэгж талбар байршилд бод 850, бог 1500 орчим малын сэг зэм, хог хаягдал цуглуулан хогийн нэгдсэн цэгийн цэгт төвлөрүүлж устгалын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Уртын голын хамгаалалтын бүст орших 7 худагт тархсан 2 га хогийн цэгийг цэгцлэж хово автомашинаар 50 удаагийн рейс буюу 150 тн хог хаягдал, малын өтөг бууцыг цэвэрлэж, зөөвөрлөн хогийн нэгдсэн цэгт устгасан. Голын эх, ай сав, хөндий татам, гуу жалга дахь үхсэн малын сэг зэм, хог хаягдал цэвэрлэх, устгах булшлах ажлын хүрээнд Сүхбаатар тохижилт үйлчилгээний газрын Ковш техник, хувийн түрээсийн хово машин ажиллалаа. /Хүснэгт-1/ Зарцуулсан зардлын тооцоо

Хүснэгт-1

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	ДТ түлш	Л	1972	3600	7100,000
3	Ажиллах хүчний зардал	Хүн/өдөр	5 өдөр	36000	900,000
4	Түрээсийн зардал	Хүн/өдөр	5 өдөр	200000	1000,000
Нийт үнэ					9,000,000

Хоёр. Баруун-Уртын голын зураг

Зураг- 1. “Баруун-Уртын гол”-ын ерөнхий байршил



Зураг-2 Баруун-Уртын голын хог хаягдлын байршил





Уст цэгийн тооллогыг аймгийн хэмжээнд 4 сав газар зохион байгуулахаар аймгийн ЗД-ын захирамж гарч санхүүжилтийг БХНСАХЗардалаас 40.260500 төг гаргана. УГГХДТСГЗахиргаанаас 10 сарын 01-ны өдрөөс эхлэн уст цэгийн тоо бүртгэлийн ажил хийгдэж байна. Түвшинширээ Уулбаян Мөнххаан сумдад ажиллаж байна. Уг ажлын хүрээнд аймгийн хэмжээнд булаг шанд, нуур, тойром худагийг мэдээллийн санд бүртгэлжүүлнэ.

Дорнод Монголын хээрийн өвөрмөц экосистемийн төлөөллүүдийг хамгаалах зорилгоор ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисстой хамтран “Дорнодын Монголын Хээр”-ийг Дэлхийн өвд бүртгүүлэх номинацийн ажлыг хэрэгжүүлэх Баянцагаан тал Байгалийн нөөц газарт 8 сарын 20-ноос 22-ны өдрүүдэд шинжээчдийн баг ажилласан.



1.6. Хяналт шалгалтын талаар:

2024 оны 05 сарын 29-ний өдөр Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтарч Хүнсний аюулгүй байдлын аяны хүрээнд газар тариалан эрхлэгч 30 иргэн, аж ахуйн нэгжүүдэд Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Химийн хорт болон аюултай бодис ашиглахтай холбоотой дүрэм журам, стандарт, хууль тогтоомжийн сургалтыг хийсэн.

Байгаль орчин аялал жуулчлалын яамны Салбарын ерөнхий байцаагчийн 01/10 тоот удирдамжийн хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 25-с 06 сарын 13-ны хооронд Дөрвөлж ОНӨААТҮГ, Сүхбаатар аймгийн хот тохижилт ОНӨААТҮГ, Цайрт минерал ХХК-д төлөвлөгөөт шалгалтыг хийж 01.1.4 кодтой хяналтын хуудсаар 2 объектын эрсдэлийн түвшинг үнэлэхэд 36.9%, хууль сахин мөрдөлт 55.3%-тай дунд эрсдэлтэй үнэлэгдэж нийт 53 зөрчил илрүүлж 35 заалттай 2 албан шаардлагыг 2 аж ахуйн нэгжид хүргүүллээ. Цайрт минерал ХХК-д Зөрчлийн тухайн хуулийн 6.1-1-1.1 дэх заалтаар аюултай хог хаягдлыг түр хадгалах нөхцөлийг биелүүлээгүй гэх зөрчилд 12 дугаартай зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 3.000.000 сая төгрөгөөр торгож шийдвэрлэсэн.

2024 оны урьдчилсан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Тунгуан майнз констракшн Монгол ХХК-д Зөрчлийн тухайн хуулийн 6.1-1-1.1 дэх заалтаар аюултай хог хаягдлыг түр хадгалах журам зөрчсөн гэх 11 дугаартай зөрчилд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 3.000.000 сая төгрөгөөр торгож шийдвэрлэсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн 01/06 тоот удирдамжийн хүрээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Дөрвөлж ОНӨААТҮГ-ын химийн лаборатори, Цайрт минерал ХХК-ын лабораторид хийж 01.1.2 кодтой хяналтын хуудсаар 2 объектын эрсдэлийн түвшинг үнэлэхэд 20.52% бага эрсдэлтэй үнэлэгдсэн.

Цагдаагийн газрын 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 45-4/1819 дугаартай албан тоотын дагуу хөрсний бохирдол үүсгэж нийтийн эзэмшлийн талбайд хог хаягдал асгасан 2 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 30.0 мянган төгрөгөөр тус тус торгож шийдвэрлэсэн.

Цагдаагийн газрын 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 45-4/2477 дугаартай албан тоотын дагуу Баруун-Урт сумын 1 дүгээр багт үйл ажиллагаа явуулдаг Дарьганга өртөө гэх хашаанд дотор хориотой ан болох тарвага шарж байсан гэх гомдол мэдээлэл зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж Зөрчлийн тухай хуулийн 7.6-5 дах заалтад зааснаар 300.000 мянган төгрөгөөр торгож 820.000 мянган төгрөгний нөхөн төлбөр оногдууллаа.

Цагдаагийн газрын 2024 оны 07 дугаар сарын 23-ний өдрийн 45-1/2535 дугаартай албан тоотын дагуу хөрсний бохирдол үүсгэж нийтийн эзэмшлийн талбайд хог хаягдал асгасан иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 50.0 мянган төгрөгөөр торгож шийдвэрлэсэн.

Түмэнцогт сумын байгаль хамгаалагч Д.Ууганбат хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад олж илрүүлсэн Дорнод аймгийн Хэрлэн сумын 4-р багийн иргэн Х.Ууганбаяр нь зориулалтын бус газарт байгалийн ургамал болох ганга өвс түүсэн гэх зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу 150.000 мянган төгрөгөөр торгож 5 шуудай 49 кг ганга өвсийг хураан авч Түмэнцогт сумын орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр батлагдсан 01/10 тоот төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Асгат сумын 1 дүгээр багт үйл ажиллагаа явуулдаг Дорнын чулуулаг ХХК 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдөр хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар аюултай хог хаягдлыг хадгалах нөхцөлийг хангаагүй гэх зөрчилд 16 дугаартай

хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж “Зөрчлийн тухай” хуулийн тусгай ангийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дэх заалтад зааснаар 5.000.000 сая төгрөгөөр торгож шийтгэл оногдуулав.

Сүхбаатар аймгийн Аудитын газрын аудитотор С.Ариунбаяраас Асгат сумын 1-р багийн нутагт үйл ажиллагаа явуулж буй “Дорнын чулуулаг” ХХК нь усны гэрээ, дүгнэлтгүй уурхайн гүний усыг шавхан зайлуулж байна гэсэн гомдол мэдээлэлтэй танилцаад Усны гэрээ, дүгнэлт гаргуулаагүй шугам хоолой тоолууржуулаагүй карьерын ус шавхан зайлуулж буй зөрчилд 17 дугаартай зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж “Зөрчлийн тухай” хуулийн 7.15 дугаар зүйлийн 2 дах хэсэгт зааснаар 5.000.000 сая төгрөгөөр торгож 2.736.000 сая төгрөгний нөхөн төлбөр оногдууллаа.

Сүхбаатар аймгийн Аудитын газрын аудитотор С.Ариунбаяраас Асгат сумын 1-р багийн нутагт үйл ажиллагаа явуулж буй “Ананд баян тал” ХХК нь усны гэрээ, дүгнэлтгүй уурхайн гүний усыг шавхан зайлуулж байна гэсэн гомдол мэдээлэлтэй танилцаад Усны гэрээ, дүгнэлт гаргуулаагүй шугам хоолой тоолууржуулаагүй карьерын ус шавхан зайлуулж буй зөрчилд 18 дугаартай зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 2 дах хэсэгт зааснаар 5.000.000 сая төгрөгөөр торгож 5.957.038 сая төгрөгний нөхөн төлбөр оногдууллаа.

Баруун-Урт сумын газрын даамал Эрдэнэхүүд харилцаа холбооны хэрэгслээр гомдол мэдээлэл ирүүлсний дагуу Баруун-Урт сумын 8-р багийн нутаг дэвсгэр “Хайлааст үүд” нэртэй газарт оршин суугч Ё.Баярцогт нь нийтийн эдэлбэр газрын өвс дэрсийг хадаж буй зөрчилд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж “Зөрчлийн тухай” хуулийн 7.7 дугаар зүйлийн 1.2 дах хэсэгт зааснаар 150.000 мянган төгрөгөөр торгож шийтгэл оногдуулав.

ЗГ-ын 2024 оны 224 дүгээр тогтоол, БОАЖСайдын 2024 оны А/548 дугаар тушаалын дагуу АЗДаргын идлэг шонхорын зөвшөөрөл олгосон.

АЗД-тай гадаадын иргэд идлэг шонхорын гэрээ байгуулж, гэрээний хавсралтыг газрын даргаар батлуулан сумдын ЗДТГ, БОХУБ, байгаль хамгаалагч нарыг идлэг шонхорын мэдээл мэдээллээр ханган ажилласан.

Идлэг шонхор шувууг соёлын зориулалтаар барих тухай ЗГ-ын 2024 оны 224 дүгээр тогтоол батлагдсан.

Аймгийн ЗДаргатай болон газрын даргатай идлэг шонхор шувуу барих зөвшөөрөл, гэрээ, гэрээний хавсралтыг батлуулан ажиллаа.

Сумдын 3Дарга болон 3ДТГ-т идлэг шонхор барих талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч 219, 221 дугаартай албан бичгийг хүргүүлэн ажилласан.

Идлэг шонхор барихаар ирж буй гадаадын иргэд, отогт БОАЖС-ын 2018 оны А/194 дүгээр тушаалаар батлагдсан “МУ-ын нутагт идлэг шонхор барих, тээвэрлэх, арчлах, гадаад улсад гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам”-ын дагуу зөвлөмж боловсруулан хүргүүлж ажилласан.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2024 оны 01 сарын 24-ны өдөр батлагдсан 01/10 тоот төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Баруун-Урт сумын Петровис ХХК, Шунхлай Говь ХХК, Сод Монгол групп ХХК, Магнайн трейд ХХК, Ти Эм Ойл ХХК-д хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтад хамрагдсан 5 аж ахуйн нэгжид 27 заалт бүхий 5 дутагдал арилгуулах 5 албан шаардлагыг хүргүүллээ.

Сүхбаатар аймгийн Прокурорын газраас харъяаллын дагуу шилжин ирсэн 14 тоо толгой зээр агнасан гэх зөрчилд 2430000815 дугаартай зөрчлийн хэрэг нээн Зөрчлийн тухай хуулийн 7.6-1.3 дагуу 5 иргэнийг 150.000 мянган төгрөгөөр торгож, нөхөн төлбөр 27.916.000 мянган төгрөгний нөхөн төлбөр оногдууллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр батлагдсан 01/10 тоот төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Мөнххаан сумын 4 дүгээр багт үйл ажиллагаа явуулдаг Алтантээл баясгалант ХХК 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан гэх зөрчилд 21 дугаартай хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж “Зөрчлийн тухай” хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2 дах заалтад зааснаар 500.000 мянган төгрөгөөр торгож шийтгэл оногдуулав.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр батлагдсан 01/10 тоот төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Сүхбаатар сумын 3 дугаар багт үйл ажиллагаа явуулдаг Каскейд майнинг ХХК 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар хөрс бохирдуулагч нүхэн жорлонтой гэх зөрчилд 22 дугаартай хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж “Зөрчлийн тухай” хуулийн 6.1 дүгээр зүйлийн 10 дах заалтад зааснаар 200.000 мянган төгрөгөөр торгож шийтгэл оногдуулав.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр батлагдсан 01/10 тоот төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Түмэнцогт сумын 2 дугаар багт үйл ажиллагаа явуулдаг Монголжүюаньли ХХК 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар

аюултай хог хаягдал хадгалах агуулахгүй түр хадгалах журам зөрчсөн гэх зөрчилд 23 дугаартай хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж “Зөрчлийн тухай” хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 заалтад зааснаар 3.000.000 сая төгрөгөөр торгож шийтгэл оногдуулав.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр батлагдсан 01/10 тоот төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Мөнххаан сумын 1 дүгээр багт үйл ажиллагаа явуулдаг Хунт өгөөж ХХК 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар дотоод хяналт шалгалтын журам батлуулан мөрдөж ажиллаагүй гэх зөрчилд 24 дугаартай хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж “Зөрчлийн тухай” хуулийн 11.2 дүгээр зүйлийн 1.2 дах заалтад зааснаар 1.000.000 сая төгрөгөөр торгож шийтгэл оногдууллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2024 оны 01 сарын 24-ны өдөр батлагдсан 01/10 тоот төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Түмэнцогт сумын Говь мастер ХХК, Сүхбаатар сумын Кинзроуд ХХК-д хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтад хамрагдсан 2 аж ахуйн нэгжид 16 заалт бүхий 2 дутагдал арилгуулах 2 албан шаардлагыг хүргүүллээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2024 оны 01 сарын 24-ны өдөр батлагдсан 01/05; 01/08; 01/06; 01/07; 01/09; 01/11 тоот урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Баруун-Урт сумын Андын Ундарга ХХК, Мөнххаан сумын Нутгийн Анар ХХК, Түмэнцогт Петровис ХХК, Аривжих Дарь ХХК-д хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтад хамрагдсан 3 аж ахуйн нэгжид 28 заалт бүхий 3 дутагдал арилгуулах 3 албан шаардлагыг хүргүүллээ.

Эрээн толгой ХХК-тай хийсэн анхан шатны шүүх хурал дээр тухайн байцаагч гаргасан шийдвэрийг хэвээр үлдээсэн.





Соёлын зориулалтаар идлэг шонхор шувуу барихад

хяналт шалгалт хийсэн ажлын тайлан

Монгол Улсын хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, дэг журмыг сайжруулах тухай” 1/5 дугаар албан даалгавар, БОУАӨЯ-ны Салбарын хяналтын газрын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 11/4058 дугаар “Хяналт шалгалт зохион байгуулах тухай” албан бичгийн дагуу холбогдох сумдтай хамтарч 2024 оны 09 дүгээр сарын 11-ээс 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрүүдэд БОАЖГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ш.Нямхүү, БОХУБ Б.Шинэчимэг нарын хамт Халзан, Онгон, Баяндэлгэр, Уулбаян сумдын нутгаар идлэг шонхор шувууны хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Соёлын зориулалтаар идлэг шонхор барих хяналт шалгалтад нийт 23 гэрээнээс 19,20,09,05,15,14,8,12,8 дугаар гэрээний иргэд-12, тээврийн хэрэгсэл-12 хамрагдсан.

Илэрсэн зөрчил, дутагдал: 15 дугаар гэрээний зөвшөөрөлтэй гэх боловч гэрээний хавсралтад нэр байхгүй 2 зөрчил, зөвшөөрөлтэй машины дугаарт дугаар нь байхгүй 2 машины дугаартай машиныг илрүүлсэн. Үүнд: дараахь 2 нэрс хамаарна.

1.Mohamad Chablakh Fkhri – 014416598

2.Machaal Chouk Osman – 014663592

Зөрчилтэй машины дугаар:

1.5085 УБЦ ланд-80

2.6830 УНӨ LX470 улсын дугаартай тээврийн хэрэгслээр явж байсныг холбогдох газарт мэдэгдэж буцаасан.

Халзан сум идлэг шонхорын 6 гэрээ, акттай, сумын дансанд 125 280 000, Уулбаян сум 83 520 000 төвлөрүүлж, Онгон сум-2, Наран сум-1 гэрээ байгуулаад байна.

Аймгийн хэмжээнд нийт 27 идлэг шонхорын гэрээг дараахь сумдад байгуулаад байна. Үүнд:

1.Халзан-7

2.Уулбаян-7

3.Баяндэлгэр-10

4.Наран-1

5.Онгон-2

Одоогийн байдлаар 20 идлэг шонхорын төлбөр 417,6 төгрөг сумын БНАТ-ын дансанд төвлөрүүлээд байна.

Хяналт шалгалтын ажлын үеэр “Шалгалтын тэмдэглэл” хөтөлсөн.

Идлэг шонхор барих хяналт шалгалтад хамрагдсан 12 тээврийн хэрэгсэлд тусгай наалтыг наалгасан. Соёлын зориулалтаар идлэг шонхор барихад дараахь нийтлэг зөрчил, дутагдал илэрснийг газар дээр нь арилгуулах болон дараахь шаардлагыг тавьсан. Үүнд:

1.Шонхорын зөвшөөрөл, гэрээ, биеийн байцаалтаа биедээ авч явах

2.Тусгайлан хэвлэсэн наалт тэмдгийг авто тээврийн хэрэгслийн зохих хэсэгт наах

3.Хаана буудаллаж, байрлаж буй газраа тухайн сум, орон нутагтаа байнга мэдэгдэх,

4.Отог буух зөвшөөрлийг сумаас авах, явахдаа мэдэгдэх, отог байх хугацаандаа буусан газраа хог хаягдлаа заасан цэгт зөвшөөрөлтэй цэгт хаях,

5.Хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөр төлөх

6.Шонхорын гэрээ, акт үйлдэж, цаг тухайд нь төлбөрөө төлж байх

7.Сум орон нутгийн байгаль хамгаалагч, БОХУБ-ын тавьсан шаардлагыг биелүүлэх, ард иргэдтэй хүндэтгэлтэй харьцах

8.Айлын мал үхэр дайрсан хэрэг гарсан учраас тухайн айлыг гомдолгүй болгох

9.Дээрх тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах саналыг албан ёсоор зохих газарт хүргүүлнэ.

Санал, дүгнэлт: Хяналт шалгалт хийсэн ажлын үр дүнгээр:

1.2 шонхорын акт үйлдүүлж, төлбөрийг сумын дансанд оруулах,

2.Хог хаягдлы гэрээ байгуулж, төлбөр төлүүлэх, хог хаягдлыг тогтоосон цэгт хаяулах,

3.Тагтааны төлбөр төлүүлж, тухайн сумын дансанд оруулах зэрэг ажлуудыг хийж, сум орон нутгаас тавих хяналт шалгалтыг эрчимжүүлсэн.

Цаашид шонхор барих хүмүүсийн тээврийн хэрэгсэлд GPS байрлуулж, онлайнаар хаагуур явсан, буудалласан, отоглосон, шувуу барьсан талаарх мэдээллийг бүртгэдэг байхгүй бол хөдөө орон нутагд бэлчээрийн талхагдлыг ихэсгэж хаа сайгүй давхиж байна.

Мөн явсан км бүрт төлбөр ногдуулж тухайн сумын дансанд оруулах шаардлага гарч байна.



ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН
МЭРГЭЖИЛТЭН: Ц.ОЮУНГЭРЭЛ